## АГУУЛГА

**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

1.1 Төслийн товч танилцуулга ........ 3

**ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

2.1 Төслийн гол сөрөг нөлөөлөл ........ 4

**ГУРАВ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 5

3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ........ 21

3.3 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт........ 22

3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 25

3. 6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт........ 26

3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 26

3. 9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ........ 27

**ДҮГНЭЛТ**

## ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1, 2 Уурхайд хэрэглэж байгаа маскны төрлүүд

Зураг 3,4,5,6: Мод тарьж байгаа нь

Зураг 7,8: Мод суулгах талбай бэлдсэн нь

Зураг 9, 10: Мод услах үе

Зураг 11,12: Зам талбайг услах нь

Зураг 13,14, 15 Хоосон чулууг зам талбайд ашиглаж байх нь

Зураг 16, 17 үйлдвэрийн засварын цех нь

Зураг 18: Хаягдалын далан

Зураг 19, 20: Уурхайн бүс хаалга болон аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ

Зураг 21- 24: Ургамлын төрлүүд

Зураг 25,26: Ургамалын судалгаа авсан талбай

Зураг 27, 28 Шувуу үргээгч враш

Зураг 29,30: Булаг хашааллаж байгаа нь

Зураг 31,32, 33, 34 Угтах хаалга хийж байгаа нь

Зураг 35: Хогын савнууд

Зураг 36: Цэвэрлэгээ хийх үед

Хавсаралт -1 Усны бичиг баримт

Хавсаралт- 2 Агаар, ус, хөрсний шинжиллэгээ

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун тийш 1663 км, Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоос баруун зүгт 55-60 км, Цэнгэл сумын төвөөс зүүн хойд зүгт 7 км, Улаанхус сумаас баруун тийш 30 км зайд, Ховд голын Хар салааны бэлчир нэртэй газарт, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн M-45-107 хавтгайд, 1802.56 гектар талбайг эзлэн оршино.

*Зураг 1.Төслийн талбайн сансрын зураг*

| | |
|---|---|
| **Төсөл хэрэгжүүлэгч** | “Эс Жи групп” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011008070, Регистрийн дугаар: 2621169 |
| **Төслийн нэр** | “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн орд |
| **Төсөл хэрэгжүүлэгч ийн хаяг** | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Сор” ХК-ийн 2-р давхар, Утас: 70122639, 70124901 |
| **Төслийн зорилго** | Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших “Цагаан-Овоот уул” нэртэй алтны үндсэн ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино. |
| **Тусгай зөвшөөрлийн дугаар** | “Эс Жи групп” ХХК-нь MV-021083 дугаар бүхий 1802.56 га талбайг ашиглах ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгөөр Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байна. |

"Эс Жи групп" ХХК нь ажлын туршлага боловсон хүчин, техник, технологийн материаллаг баазадаа тулгуурлан Цагаан-Овоот уул алтны үндсэн ордыг жилийн хугацаанд ашиглаж, хаалтын жилд нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгнө.

***Ашиглах хугацаа***

Далд уурхай нь бүрэн хүчин чадалдаа хүрэхээс өмнө газрын дээрх болон доорх барилга байгууламжийн ажил, газрын гүндэх үндсэн малталтуудыг нэвтрэх, тэдгээрийг бүрэн тоноглож бэхлэх, нээх бэлтгэл малталтуудыг нэвтрэх, түүнээсээ олборлолтод

бэлтгэх малталтуудыг нэвтэрч хүдрийг олборлолтод бэлтгэх нураалтын ажлуудыг хийх тул олборлолтын ажил эдгээр ажлууд хийгдсэний дараа бүрэн хүчин чадлаараа ажиллана.

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### 2.1 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээнээс дүгнэн уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг доор авч үзлээ.

- Уурхайн бүтээн байгуулалт, олборлолт, үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 14.57 га талбай эвдрэлд өртөх
- Баяжуулах үйлдвэрийн хаягдал, хаягдлын сангаас бохирдол үүсэх
- Хүнд даврын машин механизмын авто зам, бусад үйл ажиллагаанаас үүдэн ургамлан нөмрөг доройтох, хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орох

Иймд Цагаан-Овоот уул нэртэй алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн БОНБНҮ-ний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж хэсэг мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан зөвлөмжийг мөрдөж уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байдлаар явуулаж байна.

# ГУРАВ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

### *3.1.1 Агаарын чанар*

Далд уурхайн үйл ажиллагааны үед тоосжилт үүсэх учраас далд уурхайд ажиллагсадад зориулалтын маскаар хангаж ажлуулдаг. Мөн тээврийн хэрэгслийн зорчих замыг засаж, сайжруулсан шороон зам тавиж хур тундас бага орсон үед үйлдвэрийн эргэн тойроныг усалдаг.





*Зураг 1, 2 Уурхайд хэрэглэж байгаа маскны төрлүүд*

Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор болон “Тэрбум мод” хөтөлбөрт хамарагдаж баяжуулах үйлдвэрийн эргэнд хайлаас, улиас, бургас зэрэг модны төрлүүдийг 3000 $м^2$ болон 3 га талбайд тарьсан.










*Зураг 3,4,5,6: Мод тарьж байгаа нь*





*Зураг 7,8: Мод суулгах талбай бэлдсэн нь*





*Зураг 9, 10: Мод услах үе*

Тээврийн хэрэгсүүдийн зорчих замыг засаж, сайжруулсан шороон зам тавиж, зам талбайг халууны улиралд хур тунадас багатай үед усалдаг.






*Зураг 11,12: Зам талбайг услах нь*

## 3.2 Гадаргын ба газрын доорх усны нөөцийн тухай

Үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр ашиглах тул жил бүр мэргэжлийн байгууллагаар ус ашиглах дүгнэлтээ гаргуулж, усны нөөц, чанарыг хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу тухай бүрт арга хэмжээ төлөвлөн гүйцэтгэдэг. Холбогдох баримт бичгийг **хавсаралт 1** дээр тусгаж өгөв.

## 3.3 Хөрсөн бүрхэвч

Далд уурхайгаас гарсан хоосон чулуулгийг зам талбайг бэлтгэхэд ашиглаж, зам хийх, карьер хийхээс урьдчилан сэргийлэх







*Зураг 13,14, 15 Хоосон чулууг зам талбайд ашиглаж байх нь*

Машин механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр талбайд хийж гүйцэтгэдэг.



*Зураг 16, 17 үйлдвэрийн засварын цех нь*

Хаягдлын далангийн үер ус зайлуулах суваг шуудууг хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, сэргээн засах ажлыг жил бүр зохион байгуулдаг.



*Зураг 18: Хаягдалын далан*

### 3.4 Газрын хэвлий

Төсөл хэрэгжүүлэх хугцаанд батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглана.

Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүнд ИТА-д хяналт тавих, хариуцан ажлуулдаг.







*Зураг 19, 20: Уурхайн бүс хаалга болон аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ*

## 3.5 Ургамлан нөмрөг

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын хэмжээг бууруулах, ургамлан нөмрөгийг талхлагдахаас сэргийлэн уурхайн кемп орчимд хамгаалалтын бүс тогтоож хашааллаж, уурхай орчмаас 5 цэг сонгон авч ургамлын судалгааг хийж бүртгэлжүүлсэн. Энэ жилийн 7-р сард бороо бага байсан учраас судалгаа авах үед өвс ногоо хатсан сийрэг байсан.



*Зураг 21- 24: Ургамлын төрлүүд*






*Зураг 25,26: Ургамалын судалгаа авсан талбай*

## 3. 6 Амьтны аймаг

Хайгуул, олборлолтын үед үүссэн илүүдэл нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь булж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхдэг. Энэ жил ил цооног болон техникийн нөхөн сэргээлт хийх шаардлага байхгүй байсан.

Төслийн талбайн ойр орчим, хаягдалын далангын ойр, шувуу үргээх хэрэгслүүдийг байршуулсан. Уурхайн талбайн бүрэн хашаа хамгаалалтай мөн 24 цагын харуул хамгаалалтай байдаг.





*Зураг 27, 28  Шувуу үргээгч враш*

## 4.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2022 онд техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй. Шимт хөрсийг овоолох, хадгалах ажлын зардлыг сөрөг нөлөөллийг бууруулах хэсэгт тусгасаны дагуу хийж гүйцэтгэв.

## 4.3 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Энэ жил дүйцүүлэн хамгаалах ажилд орон нутгаас өгсөн санлын дагуу Борбургасын Цагаан булгыг хашаалаж эхийг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.





*Зураг 29,30: Булаг хашааллаж байгаа нь*

"Алтай таван богд" хамгаалалтын захиргаатай хамтарч Сыргалыд угтах хаалга байршуулсан.












*Зураг 31,32, 33, 34 Угтах хаалга хийж байгаа нь*

## 4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн кадастрын зураг, хээрийн судалгааны явцад тус төслийн талбайд нүүлгэх 6 айл байгаа бөгөөд эдгээр айлыг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай тохиолдолд бэлчээрийн нөхөн олговор олгоно. Одоогоор нүүлгэн шилжүүлэх шаардалага гараагүй.

### 4.4. 1 Археологийн дурсгал

Төслийн талбайд өрөмдлөг хийх, хөрс хуулах ашиглалтын бусад үйл ажиллагаа явуулах тохиолдолд илэрсэн дурсгалуудыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, дурсгалуудыг малтан судлуулж талбайг чөлөөлүүлэх, түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх, газар хөндөх ажилд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулна.

## 4.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Ажилчдын амь насанд учруулж болох осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслэлээр бүрэн хангасан.

ХАБЭА-н дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, галын аюулаас хамгаалах, төлөвлөгөөг ажилчдад танилцуулж, ажил эхлэхээс өмнө өдөр болгон аюулгүй ажлын зааварчилгаатай танилцууладаг.

Ажилчин бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, дохиолол, холбоо, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалгаж шаардалага хангасан тохилдолд ажилд гардаг.

## 4.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Оффисоос гарч буй цаасны хаягдлыг (бүх төрлийн цаасан хайрцаг, нороогүй шохойгүй хоол хүнсний бохирдолгүй байх) зориулалтын хогны саванд ангилан хаядаг.



*Зураг 35: Хогын савнууд*

Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт цуглуулан орон нутгын захиргаатай хийсэн гэрээний дагуу хогын цэгт хаядаг.

Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж үйлдвэрийн эргэн тойроны нийтийн цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа зохион байгуулдаг.



*Зураг 36: Цэвэрлэгээ хийх үед*

## 4.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр Алтны үндсэн ордын талбайн төслийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарах болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийг урьдчилан сэргээлэн үднээс холбогдох хууль дүрэм стандартын дагуу Баян- Өлгий аймгийн УЦУОШТөв лабораторид Улаанбаатар хот дах Инженер Геодез ХХК жилд 2 удаа хийлгэдэг. Холбогдох баримт бичгийг хавсарлт 2-т тусгав.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал

| Менежментийн төлөвлөгөөний биелэлт | Нийт дүн /мянга. Төг/ | |
|---|---|---|
| Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 4 000.0 | |
| Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | | |
| Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 10 000.0 | |
| Нүүлгэн шилжүүлэх , нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | | |
| Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт | 1 000.0 | |
| Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 2 500.0 | |
| Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 8 000.0 | |
| Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | 1 700.0 | |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1 300.0 | |
| Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | | |
| Химийн бодисын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | | |
| Нийт зардал | 28 500.0 | |

Эс Жи групп ХХК – ийн  Цагаан-Овоот уул нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнд нийт 28. 5 сая төгрөг зарцуулсан байна.